БАГАНУУР ХК

**"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 17 өдөр Дугаар 04

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт "Эрдэнэс Монгол" ХХК-ийн байр /хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1-р байр/, 107 тоот хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй:

2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;

2.2 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай;

2.3 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүн-Хөндлөнгийн аудитын дүгнэлтийн танилцуулга;

2.4 Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийн танилцуулга;

2.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга;

2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

2.7 Компанийн өрийг хувьцаагаар солих тухай;

2.8 Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;

3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл даргалахаар шийдвэрлэсүгэй.

4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг

дөрөвдүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загварыг тавдугаар хавсралтаар, хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал авах хуудасны загварыг зургаадугаар хавсралтаар, хурлын мэдэгдлийн хяналтын хуудасны загварыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөрт багтаан 'Санхүүгийн зохицуулах хороо", "Монголын хөрөнгийн бирж" ХХК-д бүртгүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хурлын зарыг 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин зарлахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

6.1. Хурал даргалагч - Төлөөлөл /Эрдэнэс Монгол ХХК/

6.2. Хурал зохион байгуулах комиссын дарга - Ц.Уранбилэг /Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга/

6.3. Хурал зохион байгуулах комиссын нарийн бичиг - Г.Соёлмаа /Хамтын ажиллагааны төлөөлөгч/

6.4. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Я.Отгонбаатар /Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга/
Ж.Болд-Эрдэнэ /Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга/
Б.Эрдэнэтуяа /Гүйцэтгэх захирлын туслах/
Б.Одгэрэл /Хуулийн мэргэжилтэн/
Б.Есөнцагаан /Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн/
П.Нямхүү /Худалдааны мэргэжилтэн/
Д.Дэлгэрсайхан /Комплайнсын ажилтан/
Б.Гантулга /Бэлтгэн нийлүүлэгч, жолооч/

6.5. Хурал зохион байгуулах тооллогын комиссын дарга - Хажидмаа /Дотоод хяналт, эрсдэлийн албаны дарга/

6.6. Тооллогын комиссын гишүүд:
Б.Наранцэцэг /Дотоод хяналт, эрсдэлийн албаны мэргэжилтэн/
М.Дондогдулам /Дотоод хяналт, эрсдэлийн албаны мэргэжилтэн/

7. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17.00 цагаар тасалбар болгосугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА П.БАТТӨР

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

# “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

2026.03.17 Улаанбаатар хот

| **Компанийн нэр:** | **Багануур ХК** |
|---|---|
| Хаяг, утас: | Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр хэсэг |
| Хурал хуралдах өдөр цаг: | 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цаг |
| Хурал хуралдах газар: | Улаанбаатар хот, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр /хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1-р байр/, 107 тоот хурлын танхим |
| Хурлын төрөл: | Ээлжит хурал |
| Хурал зарлагч: | “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр |
| Олон нийтэд зарлах огноо: | 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдөр |
| Бүртгэлийн өдөр: | 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр |
| Хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо: | 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр |
| Хурал даргалагчийн нэр: | Төлөөлөл “Эрдэнэс Монгол” ХХК-ийн |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр: | Дарга Б.Хажидмаа<br>Гишүүд Б.Наранцэцэг, М.Дондогдулам |
| Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/ | |
| Баримт, бичгийн хуудасны тоо | .................. ширхэг<br>...................хуудас |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 17-ны өдрийн 04 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: “Багануур” ХК

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр хэсэг

Хурал болох огноо, байршил: 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр /хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1-р байр/, 107 тоот хурлын танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04-р сарын 08-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүн-Хөндлөнгийн аудитын дүгнэлт
4. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийн танилцуулга;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;
7. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай;
8. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;

Хувьцаа эзэмшигч та 2026 оны 03 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “Багануур” ХК-ийн төв оффис болон “Багануур” ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар, харьяа брокер, дилерийн компанид очиж хурлын материалтай танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2026 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 17.00 цаг байна.

Холбоо барих утас: 99028967
И-мэйл хаяг: soyolmaa.g@baganuurmine.mn

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын гуравдугаар хавсралт

# “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

2026.03.17 Улаанбаатар хот

| № | Хурлын дэг | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Хурлын ирц бүртгэх | 60 минут |
| 2 | Хурлын ирц мэдээлэх /Зохион байгуулах комисс/ | 05 минут |
| 3 | Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг танилцуулах | 05 минут |
| 4 | Хурлын дарга хурлын үйл ажиллагааг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах | 10 минут |
| 5 | Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулах | Асуудал тус бүрээр 30 хүртэл минут |
| 6 | Хурал оролцогсдын асуулт, хариулт | хүн бүр 03 минут |
| 7 | Хуралд оролцогсдын санал | хүн бүр 03 минут |
| 8 | Завсарлага | 20 минут |
| 9 | Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах | 05 минут |
| 10 | Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах | Асуудал тус бүрээр 10 хүртэл минут |
| 11 | Хурлын ажиллагааг хаах | 05 минут |

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралт

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ
БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт
3. ТУЗ-ийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлан
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд
5. Холбогдох бусад материал

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын тавдугаар хавсралт

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .......................................Нэр...........................................

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар .....................................................................

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар.................................................................

Санал өгөх хувьцааны тоо..........................................................................................

Бүртгэсэн /брокер, дилерийн компани/

Брокерын компанийн нэр.........................................................................................

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр /хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1-р байр/, 107 тоот хурлын танхимд хуралдана .

| № | Хэлэлцэх асуудал | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; | | | |
| 2 | Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; | | | |
| 3 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга; | | | |
| 4 | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай; | | | |
| 5 | Компанийн өрийг хувьцаагаар солих тухай; | | | |
| 6 | Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай; | | | |

Брокерын ............................................. /......................................../
Хувьцаа эзэмшигчийн............................./........................................./

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын зургаадугаар хавсралт

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ........................................Нэр...........................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар ......................................................................
Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар....................................................................
Санал өгөх хувьцааны тоо.......................Кумулятив саналын тоо...............................
Бүртгэсэн /брокер, дилерийн компани/
Брокерын компанийн нэр.............................................................................................

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр /хуучнаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1-р байр/, 107 тоот хурлын танхимд хуралдана.

| № | ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог, нэр | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
|---|---|---|
| | Ердийн гишүүн | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |
| 7 | | |
| 8 | | |
| | Хараат бус гишүүн | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |

Брокерын ............................................ /........................................./

Хувьцаа эзэмшигчийн............................/........................................./

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны
өдрийн 04 тоот тогтоолын долоодугаар хавсралт

# “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

| № | Зүйл | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Компанийн нэр: | |
| 2 | Хаяг, утас: | |
| 3 | ТУЗ-ийн хурал хийсэн огноо: | |
| 4 | Хурал зарлагчийн мэдээлэл | |
| 5 | Хороонд ирүүлсэн огноо: /хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор/ | |
| 6 | Олон нийтэд зарлах огноо | |
| 7 | Эхний зарласнаас хойш 15 хоногт дахин зарласан эсэх | |
| 8 | Бүртгэлийн өдөр /нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр/ | |
| 9 | Хэлэлцэх асуудал | |
| 10 | Саналын хуудасны загвар | |
| 11 | Саналын хуудас хүлээн авах өдөр | |
| 12 | Хурлын комиссын гишүүдийн нэрс | |
| 13 | Хурал хуралдуулах огноо /шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн өмнө/ | |
| 14 | Хурал хуралдуулах газар байршил, хаяг<br>Хурал хуралдуулах огноо, цаг | ..................<br>.................. |
| 15 | Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр:<br>Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үсэг<br>Хурлын мэдэгдэл хянасан огноо | ..................<br>..................<br>.................. |